



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/667

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/05 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын нутаг дэвсгэр дээр байрлах Цахилгаан дамжуулах зориулалттай КТП-ын доорх газруудыг Ховд “Цахилгаан түгээх сүлжээ” ХХК /2684853/-д албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 03297

Аймгийн Засаг даргын 2019 оны  
10 дугаар сарын 15-ны өдрийн  
А/667 дугаар захирамжийн хавсралт



### ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Байршил	Эзэмших хугацаа	Хэмжээ /м2/	Зориулалт
1	Жаргалан баг, 30 айлын орон сууц дунд	15	58	Цахилгаан дамжуулах төв
2	Цамбагарав баг, Спортын ордон	15	37	Цахилгаан дамжуулах төв
3	Алагтолгой баг, Захын доод талд	15	68	Цахилгаан дамжуулах төв
4	Жаргалан баг. Ховд их сургууль	15	61	Цахилгаан дамжуулах төв
5	Наран баг, 2 дугаар гудамжны 18 тоот	15	67	Цахилгаан дамжуулах төв
6	Магсаржав баг, 3 дугаар сургуулийн хойд талд	15	52	Цахилгаан дамжуулах төв

-оОо-